



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/13

Баян-Өндөр сум

┌ Тусгай зөвшөөрөл сунгах, хаягийн шилжилт, ┐  
түдгэлзүүлэх, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.17, 19.18, 19.20, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дах заалтууд, 6.1 дүгээр зүйлийн 3, 6.2 дугаар зүйлийн 1.2, Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/383 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс”-ын 2024 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийн дагуу сунгалт хийх байгууллагуудыг нэгдүгээр, шинээр олгох байгууллагыг хоёрдугаар, хаягийн шилжилтийг гуравдугаар, түдгэлзүүлэх байгууллагыг дөрөвдүгээр, цуцлах байгууллагыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн газарт сар бүрийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 13 дүгээр сарын 27-ний  
өдрийн 413 дугаар тушаалын  
нэдүгээр хавсралт

9043446 2020030036

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ  
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Хугацаа
1	Ариун Орчлон клиник ХХК-ын "Тэгш нуруу" клиник	Уламжлалтын тусламж үйлчилгээ	Шинэ Эрин Мед төрөлжсөн эмнэлгийн байрны 2 давхарт	5 жил
2	Ачит нар ХХК-ын "Ачит" клиник	Дотор, уламжлалтын амбулатори болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ	Урт булаг баг, төгөл гарден	5 жил
3	Нийцэл ХХН-ын "Нийцэл" ӨЭМТ	Анхан шатны тусламж үйлчилгээ	Булаг баг	5 жил
4	Их тавт ХХК -ын Их тавт " клиник	Дотор, уламжлалтын амбулатори болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ	Дэнж баг Эвт төв	5 жил
5	Мөнх-Алтаргана ХХК-ын "Баялаг фарм" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Зэст баг, 1-р хороолол 5 байрны 14 тоот	5 жил
6	Мишээл сийлэн ХХК-ын "Анар фарм" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Уурхайчин баг, 3-р хороолол, 11 байр, 84 тоот	5 жил

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 03 дүгээр сарын 07-ний  
өдрийн 113 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР,  
ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Хугацаа
1	Батхааны өвөр хязгааргүй ХХК-ын "Аззаяа Орхон"клиник	Дотрын тусламж үйлчилгээг амбулатори, өдрийн эмичлгээ үзүүлэх	Хүрэнбулаг багийн 4-р хороололын 25-р байрны 24 тоотод нээх	5 жил

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 03 дүгээр сарын 07-ний  
өдрийн 1/13 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт



ХАЯГЫН ШИЛЖИЛТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ , ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Шилжин орон хаяг, байршил
1	ЦАГ ЧИГ ХХК-ын "Наран" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Оюут баг, 2-р хороололын 11-р байрны 03 тоотод шилжин орох



Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 03 дүгээр сарын 06-ний  
өдрийн 11 дугаар тушаалын  
дөрөвдүгээр хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Түдгэлзүүлэх хугацаа
1	Цагаандолгор ХХК-ын "Жаргалын ундрага" клиник	Уламжлалтын тусламж үйлчилгээ	Зэст баг 1-р хороолол, 5-р байрны 59 тоот	2024 оны 03-р сарын 06-нөөс 06-р сарын 06-ны өдрийг хүртэл

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 03 дүгээр сарын 07-ний  
өдрийн 113 дугаар тушаалын  
тавдугаар хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦУЦЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	Бүрэг гэрэ ХХК-ын "Их-Ундарга" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах
2	Шидэт болор ХХК –ын "Бадмаараг" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах